

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ  
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Иргэний нисэхийн ерөнхий газар  
ДАА-ын мэргэжилтэн Д.Сувдаа -99180890, 282034  
2018.01.26

№	ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА ХЭСЭГ	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо шийдвэрийн дугаар	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3.	Санхүүжилтийн үүсвэр	эх -Улсын болон орон нутгийн төсөв; -Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө; - Бусад эх үүсвэр.
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5.	Хэрэгжих нийт хугацаа	1 үе шат: 2016-2019 он 2 үе шат: 2020-2023 он
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p><b>Зорилт 2.</b> төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 3.</b> төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 4.</b> худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 5.</b> шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p><b>Зорилт 6.</b> авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;</p> <p><b>Зорилт 7.</b> авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p> <p><b>Зорилт 8.</b> иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 9.</b> улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;</p> <p><b>Зорилт 10.</b> шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 11.</b> авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.</p>


	Үүнд	Төсөв	Гүйцэтгэл
	1-р үе шат	14,308.9	499.0
	2-р үе шат	10,653.5	-
<b>ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХЭСЭГ</b>			
8.	Төсөл, хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт		
9.	<b>1 дүгээр зорилтын хүрээнд:</b> Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	<p>4.1.1.1.1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудасны <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=25474">http://www.mcaa.gov.mn/?page_id=25474</a> байршуулж нийтэд ил тод болгосон. 2017 онд АТГ-аас хянуулсан 50 ХАСУМ, 2018 оны 1 дүгээр сард хянуулсан 2 ХАСУМ-ийг байршуулсан.</p> <p>4.1.1.1.5. ИНЕГ-ын хүний нөөцийн жагсаалт, бүртгэлийг 2017 оны жилийн эцсийн байдлаар шинэчилж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=20352">http://www.mcaa.gov.mn/?page_id=20352</a> <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=14107">http://www.mcaa.gov.mn/?page_id=14107</a></p> <p>4.1.1.2.1. Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэхээр ажиллаж байгаа бөгөөд АБТ-д тухайн албан тушаалд тавих мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, тусгах болно.</p> <p>4.1.1.3.1. ИНЕГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай ч нийт ажилтнууд нь тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагч биш тул үр дүнгийн гэрээ байгуулдаггүй билээ. Ажилтнуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, хариуцлага тооцох механизмыг бий болгох зорилгоор шат дараалсан арга хэмжээг авч байна. Үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах журмыг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2017 оны А/17 дугаар тушаалаар баталж, 2017 онд ИНЕГ, түүний харьяа байгууллагын дарга нартай ИНЕГ-ын дарга үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэсэн. 2018 онд ажилтнуудын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх журам боловсруулж, гүйцэтгэлийг үнэлэх ажлыг хагас жил, жилийн эцсээр зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>4.1.1.7.1. “Ёс зүйн хороо”-г ИНЕГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна. “Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газраар хянуулж, ирүүлсэн саналыг тусган, ИНЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/363 дугаар тушаалаар баталж, байгууллагын цахим хуудаст байрлуулан нийт ажилтнуудад танилцуулж, мөрдөж байна. Ёс зүйн хороо 2017 онд 5 өргөдөл, гомдол хүлээн авч, хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтийг өргөдөл гаргагч болон харьяалах нэгжид хүргүүлсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл авах ажилтны нэр, холбоо барих утасны дугаар, E-майл хаягийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=11230">http://www.mcaa.gov.mn/?page_id=11230</a></p> <p>2017 онд 16 төлөвлөгөөт бус хяналт шалгалт гүйцэтгэж, 146 зөвлөмж өгч, шалгалтын үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулсан. Зөвлөмж 94%-тай хэрэгжлээ.</p> <p>4.1.1.10.2. Тус байгууллагын Нисэхийн сургалтын төвд зохион байгуулж буй сургалтуудын хөтөлбөрийг сургалтын хэрэгцээ шаардлага, орчин үеийн сургалтын арга барилд тулгуурлан шинэчлэн боловсруулж, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба болон бусад холбогдох байгууллагаар баталгаажуулж байна. Батлагдсан сургалтын хөтөлбөрүүдэд судалгаа хийж, шинэчлэх шаардлагатай сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж, НСТ-ийн захирлаар 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулан, шинэчлэх ажлыг шат дараатай авч хэрэгжүүлж байна. 2017 онд 59 сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, 41 хөтөлбөрийг баталгаажуулан үйл ажиллагаандаа хэрэглэж байна. 18 хөтөлбөр нь боловсруулалтын шатандаа байна.</p> <p>4.1.1.10.3 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг ИНЕГ, түүний харьяа 7 байгууллагуудын албан хаагчдад танилцуулах</p>	

		<p>хэмжээнд 527 ажилтанг хамруулсан. Хөтөлбөрийн талаарх танилцуулга, прецентейшн бэлтгэн, тус байгууллагын албан ёсны page хуудсанд байршуулсан.</p>
10.	<p><b>2 дугаар зорилтын хүрээнд:</b> Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p>	<p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 70%/</i></p> <p>4.1.2.1.1.ИНЕГ-аас олгож байгаа зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг судалж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2017 оны 4 дүгээр хурлаас ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалтад “Мэдээллийн технологийн алба”-ыг бий болгох ажлыг судалж, танилцуулахыг үүрэг болгосон. ИНЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/623 дугаар тушаалаар томилогдсон ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалтыг менежментийн түвшинд сайжруулах төсөл боловсруулах ажлын хэсэг уг асуудлыг судалж, шинээр боловсруулсан ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын төсөлд мэдээлэл технологийн асуудал хариуцсан нэгжийг байгуулахаар санал оруулсан. Энэ нэгж тусгай зөвшөөрөл олгох асуудлыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хариуцах болно. Байгууллагын цахим хуудсанд тухайн байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, холбогдох журам, маягтуудыг байрлуулж, өргөдөл гаргагчдын ажлыг хөнгөвчилж, мэдээлэл авах нөхцөл бололцоогоор бүрэн хангасан. <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=22420">http://www.mcaa.gov.mn/?page_id=22420</a> Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн 56 ИНД-ийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=13574">http://www.mcaa.gov.mn/?page_id=13574</a> Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд санал авах хуудас нээсэн. Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинэчлэн боловсруулж буй ИНД-ийн төсөлд санал авах зорилгоор ИНЕГ-ын цахим хуудсанд англи, монгол хэл дээр 50 ИНД-ийн төслийг байршуулан тогтмол санал авч байна. <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=15821">http://www.mcaa.gov.mn/?page_id=15821</a> 4.1.2.4.3. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилгоор Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, шинжилгээ судалгаа хийж, аюулгүй ажиллагааны хяналтын үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талаар журам боловсруулж байна. 4.1.2.7.1.ИНЕГ-ын үйл ажиллагаанд 2018 онд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зардал болох 10 сая төгрөгийг 2018 оны төсөвт суулгасан бөгөөд 2018 оны эхний хагас жилд хийлгэхээр төлөвлөж байна. 4.1.2.7.2 Нисэх буудлын үйлчилгээний чанарын түвшинг тогтоох, сайжруулах, шинэ үйлчилгээг бий болгох зорилгоор “Чингис хаан” ОУНБ нь жилд 4 удаа үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгаа хийж хэвшсэн. Энэ судалгааны нэг хэсэг нь үйлчилгээний ажилтнуудын ур чадвар, үйлчилгээний соёл, харилцааны асуудлыг хамардаг бөгөөд судалгаанд үндэслэн ажилтнуудыг сургалтад хамруулах, одоогийн зохион байгуулж байгаа сургалтын давтамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байна.</p>
11.	<p><b>3 дугаар зорилтын хүрээнд:</b> Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг</p>	<p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 40%/</i></p> <p>4.1.3.2.2. Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитын ажлын үр нөлөөг сайжруулах зорилгоор байгууллагын дотоод аудитын дүрэм болон Дотоод аудитын үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, ИНЕГ-ын даргын 2017 оны А/435, А/813 дугаар тушаалаар тус тус батлуулсан. ИНЕГ-ын 2017 оны хагас жилийн санхүүгийн тайланд балансын дүн шинжилгээ хийсэн бол 2017 оны төсвийн гүйцэтгэлд санхүүгийн шинжилгээ хийж, байгууллагын удирдлагад танилцуулахаар төлөвлөж байна. 2017 онд ИНЕГ-ын харьяа 11 нэгжид санхүүгийн хяналт шалгалт хийж, 155 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилт 90%-тай байна. Төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2018</p>

		<p>онд дээрх нэгжүүдэд дахин хяналт шалгалт хийхээр төлөвлөж байна.</p> <p>4.1.3.3.1.Тус байгууллагын цахим хуудасны Шилэн данс <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=8365">http://www.mcaa.gov.mn/?page_id=8365</a> хэсэгт төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын мэдээллийг тогтмол оруулж, мэдээллийг ил тод болгож, олон нийт мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн. 2017 оны жилийн эцсийн байдлаар ИНЕГ нийт 149 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг байршуулсан, 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор байршуулах 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. ИНЕГ-ын үйлдвэрлэл үйлчилгээ болон түүний харьяа байгууллага байршуулах 2774 мэдээллээс 2717 мэдээллийг 2017 оны 4 дүгээр улиралд байршуулахаас 2717 мэдээллийг бүрэн байршуулсан.</p> <p>4.1.3.4.2.Тус байгууллагын төсвийн төсөлд санал авах зорилгоор төсвийн төслийг ИНЕГ-ын цахим хуудасны Шилэн данс хуудсанд <a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=8365">http://www.mcaa.gov.mn/?page_id=8365</a> байршуулж, ажилтнууд саналаа өгөх боломжоор хангаж байна.</p> <p>4.1.3.7.2.Иргэн хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх арга хэмжээг авч байна. Үүнд: Хөвсгөл аймгийн нисэх буудлын даргаар ажиллаж байсан Д.Дугардоржоос байгууллагад учруулсан /ажилтныг хууль бусаар халж ажилгүй байсан хугацааны мөнгө олгосон/ хохирол болох 7 сая 855 мянган төгрөгийг гаргуулах талаар гаргасан Үндэсний аудитын газрын дүгнэлтийн дагуу тус газраас Хөвсгөл аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд уг хэрэг гурван шатны шүүхээр хянагдаж 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр анхан шатны шүүх рүү буцсан болно.</p> <p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 70%/</i></p>
12.	<b>6 дугаар зорилтын хүрээнд:</b> Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;	<p>4.1.6.4.4.Агаарын тээврийн салбарыг либералчлах чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулах ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/857 дугаар тушаалаар томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 40%/</i></p>
13.	<b>7 дугаар зорилтын хүрээнд:</b> Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;	<p>Ямар нэгэн төрийн бус байгууллага ИНЕГ-тай хамтран ажиллах, тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих талаар санал, санаачлага гаргаагүй байна.</p> <p style="text-align: right;"><i>/Дүгнэх боломжгүй/</i></p>
14.	<b>10 дугаар зорилтын хүрээнд:</b> Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;	<p>Авлигын нийгмийн хор, аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор ажилтнуудад сургалт явуулах 1263800 төгрөгийн зардлыг ИНЕГ-ын үйлдвэрлэлийн үйлчилгээний 2018 оны төсөвт суулгасан.</p> <p>ИНЕГ-ын 2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хийж, 2018 оны төлөвлөгөөг илүү нарийвчилж, Авлигын эсрэг тухай хууль, Алигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон АТГ-аас ирүүлсэн зөвлөмжтэй уялдуулан боловсруулж байна.</p> <p style="text-align: right;"><i>/Хэрэгжилт 40%/</i></p>
15.	Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд)	<p><b>Ололт:</b> Авлигатай тэмцэх нэгдсэн бодлоготой болж, хийх ажил илүү тодорхой болсон сайн талтай. Мөн хөтөлбөрийг үндэслэн ажилтнуудыг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зардлыг байгууллагын төсөв суулгах боломжтой болсон.</p>

		<p><b>Дутагдал:</b>          Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах сургагч багшийг бэлтгэж, төрийн байгууллагад сургалт явуулах ажил удаашралтай байна.</p> <p><b>Анхаарах асуудал:</b>          ИНЕГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хийж, 2018 оны төлөвлөгөөг илүү нарийвчилж, Авлигын эсрэг тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон АТГ-аас ирүүлсэн зөвлөмжтэй уялдуулан боловсруулж байна. Ингэснээр хөтөлбөрт тусгагдаагүй ажлууд төлөвлөгөөнд тусч, Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил илүү цогц болох боломжтой болно гэж үзэж байна.</p> АТГ-т тухайн онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг оны эхэнд байгууллагуудад хүргүүлэх шаардлагатай байна.						
16.	Санал	Авлигаас урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг шинэ шатанд гаргахын тулд ажилтнуудын авлигын талаарх ойлголт, тус байгууллага дээр авлигын эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг АТГ-тай хамтран бодиттой тодорхойлох шаардлагатай байна. Цаашид төрийн байгууллага бүрт авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажилд үнэлгээ хийж, хүрсэн түвшинг тогтоох шаардлагатай байна. Ингэснээр тодорхой хугацааны дараа суурь түвшинг хүрсэн түвшинд хариуцуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарсан үр дүнг тооцох боломжтой болох юм.						
17.	Шаардагдах төсөв	1263.8						
18.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс ихээхэн анхаарч, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг байгууллагын төсөвт тусгаж, төрийн үйлчилгээг нэг цонхонд шилжүүлэх чиглэлээр арга хэмжээг авч эхлээд байна.						
19.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	90						
<b>Бүх шатны төрийн байгууллагад хамаарах</b>								
20.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт1	Зорилт2	Зорилт3	Зорилт7	Зорилт10
62.5%		5	70	70	70	Дүгнэх боломжгүй	40	
<b>Төрийн зарим байгууллагад хамаарах</b>								
21.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 6				
40%		1	40%					
22.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /АТГ-ын үнэлгээ/	<b>Нэгдсэн үнэлгээ</b>						

Хянасан:  
 ДАА-ын дарга

 Н.Мөнхсүрэн

Боловсруулсан:  
 ДАА-ны мэргэжилтэн

 Д.Сувдаа